



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/208

Мандалговь

Сонголт дизайн ХХК-тай  
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “Эрдэнэдалай сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Сонголт дизайн” ХХК-тай 98,000,000 (ерэн найман сая) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зургийн даалгаврын дагуу “Эрдэнэдалай сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Сонголт дизайн” ХХК-ийн захирал (Я.Сумхүү)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга (Н.Түвшинжаргал) Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

401150511